



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 18 өдөр

Дугаар А/191

Улаанбаатар хот

Дүүргийн “Явган алхалтын холбоо”-нд
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Улсын Их Хурлын 2020 оны “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын зорилт 3.5 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүтээмж-Хамтын ажиллагааг дээшлүүлэх зорилтот жил, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Эрүүл Монгол хүн” хөтөлбөрийн хүрээнд Монголын явган алхалтын холбоотой хамтран 21 аймаг, 9 дүүргийн явган алхалтын холбоодын дунд “Адар баян” 100 км-ын өвлийн явган алхалтын арга хэмжээг зохион байгуулахад дүүргийн явган алхалтын холбоонд дэмжлэг үзүүлсүгэй.

2.Арга хэмжээнд зарцуулагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3.Арга хэмжээнд зарцуулагдах 4,500,400 (Дөрвөн сая таван зуун мянга дөрвөн зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4.Тэмцээнийг үр дүнтэй зохион байгуулахыг дүүргийн Явган алхалтын холбоо (М.Ванданхүү)-нд, иргэд, ажилтан албан хаагчдын оролцоог ханган, мэдээлэл, арга зүйгээр дэмжихийг Биеийн тамир, спортын хороо (Г.Тэмүүлэн)-нд, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс (Б.Цогжавхлан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оныг дүгээр сарын ны өдрийн
..... дугаар захирамжийн хавсралт



ӨВЛИЙН 100 КМ-ЫН ЯВГАН АЛХАЛТЫН АРГА
ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛАХ ТӨСӨВ

Д/д	Материалын нэр		Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Бүгд үнэ
1	Тэмдэг		ш	10,000	100	1,000,000
2	Гэрчилгээ		ш	10,000	100	1,000,000
3	Гарын бэлэг		ш	20,000	100	2,000,000
4	Хулдаасан хэвлэл		M2	18,000	13	234,000
Тэмцээний шагнал						
5	Дартс	1-р байр	ш	55,500	1	55,500
6		2-р байр	ш	44,400	1	44,400
7		3-р байр	ш	33,300	1	33,300
8	Бүжгийн тэмцээн	1-р байр	ш	55,500	1	55,500
9		2-р байр	ш	44,400	1	44,400
10		3-р байр	ш	33,300	1	33,300
Нийт дүн						4,500,400